




## ОЮУТНЫ СУРАЛЦАХУЙН ХАНДЛАГЫГ ИЛРҮҮЛЭХ ХУВИЛБАРЫГ БОЛОВСРУУЛСАН ҮЙЛ ЯВЦ, ҮР ДҮН

Б.Түмэнцэцэг<sup>а</sup>, Р.Намжилдагва<sup>б</sup>, О.Сарантана<sup>в</sup>

<sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль, ахлах багш, доктор;

<sup>б</sup>МУБИС-Боловсрол судлалын сургууль, дэд проф., доктор;

<sup>в</sup>МУБИС-Боловсрол судлалын сургууль, магистр

Холбоо барих зохиогч: o.sarantana@gmail.com 

Хүлээн авсан: 2023.11.11

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

### Хураангуй

Суралцахуйн хандлагад суралцахын ач холбогдол, сурах сонирхол, идэвх, зорилгын талаарх (ABC model) сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, зан үйл гэсэн гурван хэмжээст бүрэлдэхүүн (Smit, 1940)-ийг авч үздэг. Бид БНХАУ-ын сэтгэл судлаач Тао Дэ Чин-ий “Суралцахуйн хандлагын хэмжүүр”-ийг Brisliin-ий аргачлалаар монгол хэл рүү хөрвүүлсэн. Энэхүү хувилбараар МУ-ын 5 их, дээд сургуулийн 18-28 насны 498 оюутан (эрэгтэй-37.8%, эмэгтэй-62.2%)-ы суралцахуйн хандлагыг хэмжлээ. Уг судалгааны үр дүнг SPSS 25, AR studio програмууд ашиглан, *component analysis*, *exploratory factor analysis* аргаар шинжилсэн. Асуулга ба түүний бүтэц бүрэлдэхүүний нийцтэй байдал ажиглагдсан. Оюутнуудын суралцахуйн хандлагад суралцах явцад үүсэж буй сэтгэгдэл, мэдрэмж (сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүн); тухайн зүйлийн талаарх санал дүгнэлт, итгэл үнэмшил (танин мэдэхүйн бүрэлдэхүүн); суралцахуйн зорилго, идэвхи тэмүүлэл, эрмэлзэл (зан үйлийн бүрэлдэхүүн) нь чухал ач холбогдолтой, хоорондоо нягт уялдаа холбоотойг илэрхийлж байна. Судлаачид монгол оюутны суралцахуйн хандлагыг тодорхойлох зорилгоор энэхүү монгол хэлнээ хөрвүүлсэн асуулгын хэрэгслийг ашиглах боломжтой гэж үзэж байна.

### Түлхүүр үг

Насанд хүрэгчид, суралцахуйн хандлага, А-В-С загвар, суралцахуйн хандлагын хэмжүүр

## Удиртгал


Тогтвортой ирээдүйг цогцлоон бүтээхэд шаардлагатай амьдралын хэв маяг, зан үйл, үнэт зүйлсэд суралцах шаардлагатай байна (UNESCO, 2017). Энд суралцахуйн танин мэдэхүй, нийгэм-сэтгэл хөдлөл, зан үйлийн хэмжээс дэх харилцан хамаарлын цогц чадамжууд цөм хамааралтай. Иймээс хариуцлагатай дэлхийн иргэнийг бэлтгэхэд, өнөөгийн сургуулийн боловсролд суралцагчдын хандлага нь сургалтын үр дүнгийн үнэлгээний үзүүлэлт төдийгүй, ирээдүйн сайн сайхны төлөөх өөрчлөлтийн гүүр болно. Суралцахуйн хандлага бол суралцах үйл явц, үр дүнд шууд нөлөөлдөг чухал хүчин зүйл бөгөөд “суралцагчдын сурах зан үйлийг сонгох, чиглүүлэх, сэдэлжүүлэх, дасан зохицох зэргийг зохицуулдаг суралцахуйн зорилгын нэг” (Гагне, 1985). “Суралцахуйн хандлага нь үзэл баримтлалын уялдаа холбоог ойлгох, асуудлыг шийдвэрлэх үндэс”(Brophy & Good, 1984), “Суралцахуйн хандлага нь суралцах сэтгэл зүйн бэлтгэлийн нэг төрөл.” (Жу Жишянь, 1970). “Хандлагын өөрчлөлт нь зан үйл, мэдрэхүй, танин мэдэхүйн өөрчлөлтөд хүргэдэг учир багш нарын хувьд сурган хүмүүжүүлэх арга барилаа сайжруулах, суралцагчдынхаа мэргэжлийн хөгжил, идэвхтэй суралцахуй, суралцах арга, техник, оюун ухаан” (Качук В. Т., 2006) – аа дайчлахад тэдний оролцоог дэмжин, хамтын ажиллагаа, нэгдсэн сургалт, орчин үеийн идэвхтэй сургалтын арга зүй, асуудлыг шийдвэрлэх, төлөвлөх, үнэлэх зэрэгт илүү анхаарлаа хандуулах нь зүйн хэрэг. Судлаачид оюутны суралцахуйн хандлагыг ойлгож, мэдрэх, судлахад мэдээллийн дэмжлэг үзүүлэх, сайжруулах талаар судалж, туршсан байна. Тухайлбал: О.Мягмар нар (2018) “Багш мэргэжлээр суралцах хугацаанд оюутнуудын аливааг зохицуулах ухаан, ойлгомжтой ярьдаг, хариуцлагатай байх зэрэг мэргэжлийн ёс суртахууны шинж чанарын төлөвшил сайжирсан үзүүлэлттэй байгаа нь МУБИС-ийн багш боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт эерэг хандлагатайг харуулна (х. 355-356). Г.Уртнасан нар (2018) “Сургалтын орчин, оюутан суралцагчдын оюуны чадамж, сурах хүслээс хамааран багшийн заасан хичээлийг үр дүнтэй хүлээн авах нөхцөлийг бүрдүүлдэг”. О.Жаргалсайхан (2021) “Суралцагчийн хандлагад нас, хүйс, амьдарч буй орчин, курс, хот хөдөө, хүсэл сонирхол, сургалтын орчин зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг. Иймд өөрийн үнэлгээ ба суралцахуйн хандлага салж болшгүй уялдаа холбоотой бөгөөд өөрийн үнэлгээ өндөр бол суралцахуйн хандлагын үнэлгээ өндөр болж, буурвал мөн адил буурдаг” (х.141). Жан Шуань Юн (2006) ”Оюутны суралцахуйн хандлагад дасан зохицох чадвар, суралцах агуулга, сэдэл, сургуулийн орчин илүү хамааралтай” (х.46). Хү Ши Жинь (2002) «Насанд хүрэгчдийн суралцахуйн хандлага нь гадны сэдэлт нөлөөллөөс үүсдэг. Насанд хүрэгчид сурах үйл ажиллагаанд оролцохдоо өөртөө итгэх итгэл тийм ч их биш”. Чен Ён (2021) «Насанд хүрэгчдийн буюу их дээд сургуулийн оюутнуудын суралцахуйн хандлагын судалгаа» нийтлэлд суралцахуйн хандлагын тодорхойлолтыг суралцагчийн сурахын үнэ цэнээр үнэлнэ. Оюутнууд зөвхөн үнэ цэнтэй гэж үзэж буй сургалтын объектод суралцах эерэг хандлагатай, харин үнэ цэнгүй гэж үзсэн сургалтын объектод суралцах сөрөг хандлагатай байна(х. 57). Энэ мэтчилэн суралцахуйн хандлага нь сургалтын чанар, үр дүнд нөлөөлөх чухал элемент болох нь олон судалгааны үр дүнгээс илэрнэ. Гэвч хүний ухамсарт оршиж байгаа хандлагыг хэрхэн хэмжиж, илрүүлэх нь төвөгтэй асуудал.

Хүснэгт 1. Монгол болон Хятад оюутны суралцахуйн хандлагыг илрүүлэх хэрэгсэл боловсруулж, туршсан зарим эрдэмтдийн бүтээлийн тойм:

	Судлаачид	Хандлагыг хэмжих арга, хэрэгсэл	Онцлог, үр дүн
1	О.Мягмар, Б.Туяа, Э.Октябрьжаргал (2016)	Багшийн хандлагыг үнэлэх рубрикийн нэгэн хувилбар	Багшийн тогтвортой сурч, боловсрох хандлага; Багшийн олон талт харилцаа хандлага; Багшийн хамтран ажиллах хандлага; Мэргэжлийн мэдлэг ур чадварын үнэлгээнд үндэслэсэн
2	Э.Октябрьжаргал, Ш.Ичинхорлоо, О.Мягмар (2018)	Өөрийн төсөөллийн арга	Хошин мэдрэмжтэй байх, аливаа зүйлийн арга эвийг олох, бусдаас хараат бус байх, багш болох хүсэл тэмүүлэл, нухцтай, хичээнгүй байх, чин сэтгэлээсээ байх, өөнтөглөж цэцэрхэхгүй байх, бусдыг манлайлдаг байх онцлогт тулгуурласан
3	Г.Ургнасан, С.Эрдэнэтуяа, Ц.Оюун (2018)	GDV Scientific laboratory program-ын арга	Суралцах идэвх, бүтээмжийн чадвар, мэдлэгийн түвшний үнэлгээнд суурилсан
4	О.Жаргалсайхан (2021)	Асуулга, өөрийн үнэлгээ	Хувь хүний итгэл үнэмшил, үзэл бодол, хариуцлага, сурах арга барил, мэдлэг, туршлага, хэрэгцээ, сонирхол гэх мэт хүчин зүйлсийг судлах
5	О.Мягмар, Б.Туяа, Ц.Бурмаа (2018)	Хандлага – 18 - А, Б хувилбар	Кэйс-тэст, ажиглалт, ярилцлагын багц хэмжүүр
6	Тао Дэ Чинь (2001)	Асуулга	Суралцахуйн хандлагыг төлөөлөх 11 бүрэлдэхүүнт асуулгын хувилбар
7	ЯН ЛИ (2018)	Асуулга, ярилцлага	Тао Дэ Чиний асуулгад үндэслэн 27 асуулга боловсруулж, ашигласан.
8	Шү Буо Лин (2014)	Асуулга, ярилцлага	Оюутнуудын сурах хандлагын түвшинг хүйс, үндэс угсаа, анги, мэргэжил, гэр бүлийн эдийн засгийн нөхцөл зэрэг гадаад хүчин зүйлийн нөлөөллийг судлах хэмжүүр

Эдгээр судлаачдын олонх (S.Rosenberg болон Carl.Hovlan гэх мэт) нь хандлагын гурвал онол (А-В-С)-д үндэслэн, суралцахуйн хандлагыг илрүүлэх хэрэгслийг боловсруулж, туршсан. А.Смит (1942) “тогтсон хандлагын бүтцэд: танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйл”-ийн гэсэн хоорондоо уялдаа холбоо бүхий гурван бүрэлдэхүүн хэсгийг ялган авч үзэхийг санал болгож, бүдүүвчлэн тэмдэглэжээ.

Загвар 1. Тогтсон хандлагын гурвал бүтэц



Хандлагын сэтгэл хөдлөл, зан үйл, танин мэдэхүйн түвшний бүтэц нь суралцахуйн хандлагын хэмжээст тодорхой стандарт онолыг бий болгосон. Сурах хандлагын агуулга, бүтцийн талаар Ли Сяо Пин суралцах хандлагыг танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, хүсэл эрмэлзэл, зан үйл гэсэн дөрвөн зүйлд хувааж, авч үзсэн бол Шен Дели оюутны суралцахуйн хандлагад суралцахын ач холбогдол, зорилгод тулгуурласан танин мэдэхүйн бүрэлдэхүүн хэсэг, сурах сонирхолд суурилсан сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүн хэсэг болон суралцах идэвх, санаачилгад тулгуурласан зан үйлийн чиг хандлага (ABC загвар) хэмээх гурван хэмжээст бүтцийг “Суралцахуйн хандлагад эдгээр гурван бүрэлдэхүүн хэсгийг заавал авч үзэх ёстой” гэж онцолсон байна.

## Арга зүй

Бид энэхүү судалгаанд БНХАУ-ын сэтгэл судлаач Тао Дэ Чинь(Tao De Qing)-ы боловсруулсан “Насанд хүрэгчдийн суралцахуйн хандлагыг илрүүлэх” судалгааны асуулгын аргачлалд суурилан, оюутны суралцахуйн хандлагыг илрүүлэх хэмжүүрийн Монгол хэл дээрх нэгэн хувилбарыг боловсруулах зорилго дэвшүүлсэн. Тао Дэ Чинь(2001)-ий суралцахуйн хандлагыг илрүүлэх хэмжүүр нь танин мэдэхүй, сэтгэл хөдлөл болон зан үйлийг төлөөлөх 27-н хаалттай асуулт, 4-н нээлттэй асуултаас бүрдэнэ. Асуулгын монгол хэл дээрх хувилбарыг АНУ-ын эрдэмтэн Brislin-ий орчуулгын стандарт загварын аргаар хөрвүүлж, тохирцтой болон найдвартай байдлыг МУ-ын 5 их дээд сургуулийн 498 оюутнаас “Google form” дижитал хэрэгслээр өгөгдөл цуглуулж, үр дүнг SPSS, AR studio статистик өгөгдөл тооцооллын хэрэгслүүдээр шинжилсэн.

## Судалгааны үр дүн

Суралцахуйн хандлага илрүүлэх асуулгыг монгол хэлнээ хөрвүүлэх үйл явцыг АНУ-ын эрдэмтэн Brislin-ий орчуулгын стандарт загвараар хөрвүүлсэн.

## Хүснэгт 2. Монгол хэлнээ хөрвүүлэх үйл явц, үр дүн

Алхам	Үйл явц		Үр дүн
А	SL /хятад эх дээрх анхны өгөгдөл/		Асуулгын монгол орчуулгын эхний хувилбар
	TL <sub>1</sub>	TL <sub>2</sub>	
	Хятад, Монгол хос хэлтэй хоёр мэргэжилтэн эх хэлнээс зорилтот хэл буюу Монгол рүү нэгэн зэрэг тусдаа бие даан орчуулна.		
	Хятад хэлний мэргэжлийн орчуулагч Н.Ч /Монгол орчуулагч/	Хятад хэлний мэргэжлийн орчуулагч О.С /ӨвөрМонгол орчуулагч/	
	BT <sub>1</sub>	BT <sub>2</sub>	
	Монгол хувилбарыг Хятад руу буцааж, орчуулна		монголоос хятад хэл рүү буцааж, орчуулсан хувилбар
	МУБИС, БСС-ийн СС-ын тэнхимийн магистрант Р.А	МУБИС, БСС-ийн БСАЗ тэнхимийн докторант Д.Р	
	GD / Бүлгийн хэлэлцүүлэг/		
	Эх хэл /Хятад/ дээрх үндсэн хувилбарыг орчуулгын хувилбартай харьцуулан, хэлэлцэнэ.		Монгол оюутны суралцахуйн хандлагыг илрүүлэх асуулгын хувилбар
	Хамтарсан хэлэлцүүлэг онлайн хэлбэрээр явагдсан. Оролцогчид: МУБИС, БСС-ийн багш, проф Р.Н МУБИС, БС-ийн багш, доктор Б.Т Докторант О.С, орчуулагч Н.Ч нар		
Мэргэжлийн экспертийн шинжилгээ хийлгэсэн. Эксперт: Сэтгэл судлаач, доктор Э.О Боловсрол судлаач, проф Р.Н			


Монгол хэл рүү хөрвүүлсний дараа асуулгын тохирцтой болон найдвартай байдлыг шинжлэхэд, сэтгэл хөдлөл бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициент 0.888, танин мэдэхүй бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициент 0.887, зан үйл бүрэлдэхүүний найдвартай байдлын коэффициент 0.865. Бүхэлд нь найдвартай байдлын коэффициент 0.949. Эдгээр Cronbach's Alpha утга > 0.7 байгаа нь хэмжигдэхүүн итгэж болохуйц гэж харуулсан.

Харин КМО=0.972, p(sig)=.000 байгаа нь түүвэр хүрэлцээтэй, фактор шинжилгээ хийхэд тохиромжтой үр дүнг илтгэсэн ч 9(=0.469), 12(=0.407) болон 27(=0.485) дугаар асуултуудын extraction хувьсагчид <0.4 буюу төлөөлөх чадвар сул, статистикийн хувьд нийцгүй асуултууд байгааг харуулж байна. Эндээс бид чанаргүй хувьсагч, өгөгдлүүдийг ялгаж (Zero Variance), хассан.

Хүснэгт 3. Нийт вариацийн утгуудын төлөөлөх чадвар

	Initial Eigenvalues			Extraction Sums of Squared Loadings			Rotation Sums of Squared Loadings			
	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %	Total	% of Variance	Cumulative %	
1	12.860	47.630	47.630	12.860	47.630	47.630	8.016	29.689	29.689	
2	2.642	9.784	57.414	2.642	9.784	57.414	6.282	23.266	52.955	
3	1.367	5.064	62.477	1.367	5.064	62.477	2.571	9.522	62.477	
4	.831	3.077	65.554							
5	.782	2.897	68.451							
6	.713	2.640	71.092							
7	.611	2.262	73.354							
8	.566	2.097	75.451							
9	.541	2.005	77.456							
10	.536	1.987	79.443							
11	.499	1.847	81.290							
12	.488	1.809	83.099							
13	.465	1.723	84.822							
14	.432	1.600	86.422							
15	.405	1.501	87.924							
16	.394	1.458	89.382							
17	.364	1.347	90.729							
18	.337	1.250	91.979							
19	.311	1.152	93.131							
20	.302	1.118	94.248							
21	.272	1.007	95.256							
22	.267	.990	96.245							
23	.248	.919	97.165							
24	.235	.871	98.035							
25	.204	.756	98.791							
26	.169	.626	99.417							
27	.157	.583	100.00							

Extraction Method: Principal Component Analysis.




Бидний асуулгын загвар таамаглалд нийцэж байгаа эсэхийг хэд хэдэн хүчин зүйлийг хэмжих замаар харж болно. Загварт эхлээд  $p$  утгыг тооцоолсон бөгөөд энэ нь  $< 0.05$ -аас бага байгаа нь тухайн загвар ач холбогдолтой гэсэн үг. Хи-квадрат нь мөн ижил үр дүнг харуулж байна. Загварын тохирох индексийн хувьд CIF болон TLI-ийн утгууд 0.80-аас дээш байгаа нь загвар нь үндсэн загварт хангалттай сайн нийцэж буйг илтгэнэ.

Latent Factor	Indicator	B	SE	Z	p-value	Beta
Сэтгэл хөдлөл	q1	1.130	0.033	34.186	0.000	0.867
Сэтгэл хөдлөл	q2	0.708	0.036	19.915	0.000	0.585
Сэтгэл хөдлөл	q3	0.740	0.031	23.715	0.000	0.673
Сэтгэл хөдлөл	q4	0.899	0.032	27.988	0.000	0.760
Сэтгэл хөдлөл	q5	1.085	0.034	32.127	0.000	0.834
Сэтгэл хөдлөл	q6	1.011	0.032	31.854	0.000	0.829
Танин мэдэхүй	q7	1.266	0.035	35.809	0.000	0.891
Танин мэдэхүй	q8	1.325	0.037	35.857	0.000	0.892
Танин мэдэхүй	q9	0.114	0.041	2.812	0.005	0.091
Танин мэдэхүй	q10	0.725	0.035	20.974	0.000	0.610
Танин мэдэхүй	q11	0.863	0.035	24.970	0.000	0.699
Танин мэдэхүй	q12	0.311	0.037	8.386	0.000	0.267
Танин мэдэхүй	q13	1.322	0.037	35.929	0.000	0.893
Танин мэдэхүй	q14	1.256	0.037	34.359	0.000	0.869
Танин мэдэхүй	q15	1.143	0.036	31.809	0.000	0.828
Зан үйл	q16	0.984	0.032	30.811	0.000	0.813
Зан үйл	q17	0.682	0.032	21.154	0.000	0.617
Зан үйл	q18	-0.217	0.049	-4.450	0.000	-0.144
Зан үйл	q19	0.660	0.034	19.171	0.000	0.570
Зан үйл	q20	0.863	0.034	25.450	0.000	0.712
Зан үйл	q21	0.916	0.032	28.933	0.000	0.780
Зан үйл	q22	0.950	0.030	31.555	0.000	0.826
Зан үйл	q23	1.011	0.031	32.806	0.000	0.847

Зан үйл	q24	0.943	0.031	30.510	0.000	0.808
Зан үйл	q25	0.550	0.037	14.846	0.000	0.457
Зан үйл	q26	0.794	0.032	24.689	0.000	0.696
Зан үйл	q27	0.082	0.042	1.978	0.048	0.064

Дээрх хүснэгтийн #P утга нь ямар хүчин зүйл чухал, чухал бус болохыг харах боломж олгодог. Регрессийн хувьд  $p$  утга  $0.05$ -аас бага байх хувьсагч нь ач холбогдолгүй. Бидний энэхүү загварт ямар ч хувьсагч нь ач холбогдлын түвшингээс өндөр  $p$  утгагүй боловч 27 ба 9-р асуултууд ойрхон байна. Энэ нь манай Q27(асуулт 27) болон Q9(асуулт 9) нь хамгийн сайн тохирох асуулгын нэг асуулт байж чадахгүй байх магадлалтай. Эдгээр асуултын Бета утга нь  $0.1$ -ээс бага байгаа тул энэхүү магадлалыг баталж байна. Мөн фактор 1 (сэтгэл хөдлөл)-т суралцахуйн хандлага илрүүлэх асуулгын 1-6 хүртэлх хувьсагчид харьяалагдаж байгаа бол 7-15 хүртэлх хувьсагчдын хувьд фактор 2(танин мэдэхүй) -т, харин 16-27 хүртэлх хувьсагчид нь фактор 3(зан үйл) -т хамаарна. Үүнийг AR studio програмаар баталгаат байдлыг шинжилж, суралцахуйн хандлагыг илрүүлэх хувилбарын асуулгуудын хамаарлыг дараах загвараар харууллаа.

Загвар 2. Суралцахуйн хандлагыг илрүүлэх асуулгын хүчин зүйлийн хамаарлын загвар



Эндээс 27-н асуулгад хувьсагч тус бүрийн харьяалах факторуудыг харж болох юм.

## Хүснэгт 4. Суралцахуйн хандлагын асуулгын дотоод бүтэц, уялдаа холбоо

Анхдагч хэмжээс	Хоёрдогч хэмжээс	Асуулга
Сэтгэл хөдлөл	Суралцах явцаас бий болсон сэтгэлийн хөдөлгөөн	Асуулт 1, 2
	Өөрт болон өрөөл бусдад бий болсон сэтгэлийн хөдөлгөөн	Асуулт 3, 4, 5
	Сониуч	Асуулт 6
Танин мэдэхүй	Суралцахуйн зорилго болон ач холбогдлын талаарх ойлголт	Асуулт 7, 8, 9
	Суралцахын агуулга болон хичээлийн дүнгийн талаарх ойлголт	Асуулт 10,11,12
	Суралцах арга болон заах аргын талаарх ойлголт	Асуулт 13,14,15
Зан үйл	Идэвхт санаачилгатай суралцах	Асуулт 16,17,18
	Төлөвлөгөөтэй суралцах	Асуулт 19, 20
	Суралцах аргыг эзэмших	Асуулт 21, 22, 23
	Суралцахад тулгарсан бэрхшээл саадыг даван туулах	Асуулт 24, 25
	Суралцахад нөлөөлж буй хүчин зүйл болон асуудлыг шийдэх	Асуулт 26, 27

Эндээс оюутны суралцахаас үүдэлтэй сэтгэл хөдлөлийн туршлага, сониуч байдлын илрэл зэрэг нь суралцахуйн хандлагын сэтгэл хөдлөлийн хүчин зүйлс болж чадна. Харин сургалтын зорилго, ач холбогдол, суралцахуйн агуулга болон хичээлийн дүнгийн талаарх ойлголт, суралцах арга, заах аргын талаарх ойлголт зэрэг нь танин мэдэхүйн түвшний хүчин зүйлс болно. Тэдний идэвх санаачилгатай, төлөвлөгөөтэй суралцах, суралцах аргыг эзэмших, суралцахад тулгарсан саад бэрхшээлийг даван туулах, нөлөөлж буй асуудлыг шийдэх зэрэг нь зан үйлийн хүчин зүйлс болж чадна гэдгээр асуулгын ерөнхий бүтэц хүчин төгөлдөр болохыг илтгэж байна. Харин суралцахуйн хандлагыг илрүүлэх нээлттэй асуултууд(28-31)-ын үр дүнг хариултын давтамжаар нь бүлэглэн, эрэмбэлж, анализ хийх боломжтой. Гэхдээ судалгаанд оролцогчдын нийгэм-соёлын болон хэлний ялгаатай байдлаас үүдэлтэй судалгааны хүрээнд хамаарах зарим нэр томъёоны ойлголтыг ташаа, зөрүүтэй ойлгох магадлалтайг анхаарах шаардлагатай.

### Дүгнэлт

Бид БНХАУ-ын сэтгэл судлаач Тао Дэ Чин(Тао De Qing)-ы боловсруулсан “Суралцахуйн хандлагыг илрүүлэх” судалгааны асуулгыг Brisllin-ий аргачлалаар орчуулан, засварласан Монгол хувилбарын хүчин төгөлдөр байдлыг КМО болон Bartlett тестээр шинжлэхэд, КМО=0.949 буюу 0.7-с их,  $p(\text{sig})=0$ , Cronbach's Alpha > 0.949 байгаа нь болон хүлээгдэж буй хэмжигдэхүүнтэй нийцэж, асуулгын ерөнхий бүтэц хүчин төгөлдөр гэдгийг илтгэсэн. Энэ нь бидний судалгааны үр дүн итгэж болохуйц үр дүн гэдгийг баталж байна. Хамаарлын шинжилгээгээр оюутны суралцахуйн хандлагад суралцах үйл явц дахь сэтгэл хөдлөл, танин мэдэхүй,

зан үйлийн элементүүд аль аль нь чухал байр суурьтай байна. Өөрөөр хэлбэл, оюутнуудын суралцахуйн хандлагад сурах үйл явцад үүсч буй сэтгэгдэл, мэдрэмж (сэтгэл хөдлөлийн бүрэлдэхүүн) гэх мэт, тухайн зүйлийн талаарх санал дүгнэлт, итгэл үнэмшил(танин мэдэхүйн бүрэлдэхүүн) гэх мэт, суралцахуйн зорилго, идэвхи тэмүүлэл, эрмэлзэл (зан үйлийн бүрэлдэхүүн) гэх мэт нь чухал ач холбогдолтой, хоорондоо нягт уялдаа холбоотой байна.

Иймд судлаачид МУ-ын их, дээд сургуулийн оюутны суралцахуйн хандлагыг тодорхойлох зорилгоор энэхүү Монгол хэлнээ хөрвүүлсэн асуулгын энэхүү хувилбарыг шууд ашиглах боломжтой.

## Талархал

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд тусалж, дэмжлэг үзүүлсэн МУБИС, ХААИС, ШУТИС, МУИС, ЭМ АЙ ЮУ сургуулийн судалгаанд оролцогч оюутнуудад талархал илэрхийлье.

## Ном зүй

Brophy, J. E., & Good, T. L. (1984). Teacher behavior and student achievement (Issue 73). Washington, DC: Institute for Research on Teaching, Michigan State University.

Çetin, Ş. (2006). Establish of the Professsion of Teaching Attitude Scale (The Study for Validity and Confidence). G.U. Journal of Industrial Arts Faculty. (G.Ü.Endüstriyel Sanatlar Fakültesi Dergisi). v.:18. (pp. 28-37).

Colman, A. M. (2015). Oxford Dictionary of Psychology (4 хян.). Oxford University Press.

Gardner, R. C. (1985). scial.Psychology and Second Language Learning,the role of Attitude and Motivation. London: Edward Arnold.

Zimmerman. (огноо байхгүй). The Faetored Dimensions of the Study Attitudes and Method Survey Test-Experimental Form . Studies in Higher Education , 33-36.

Wirth K.R. &Perkins (2008). Learning to Learn. <http://geology.wvu.edu/dept/faculty/hirschd/courses/2012/winter/306/handouts/Learning.pdf>.

Жаргалсайхан, О. (2021). Суралцагчын өөрийн үнэлгээ болон суралцах хандлагын хамаарлыг судалсан нь. Улаанбаатар.

Мягмар, О., Тамир, Х., & Бурмаа, Ц. (2018). МУБИС-ийн суралцагчдын хандлагын үнэлгээ. Боловсролын чанар, үр дүн (хуудсд. 67-77). Улаанбаатар: EduPress.

Мягмар, О., Туяа, Б., & Октябржаргал, Э. (2016). Хандлагын онол-Аргагүйн зарим загварт хийсэн дүн шинжилгээ. Сэтгэл судлалын орчин үеийн асуудлууд-Инноваци (хуудсд. 9-25). Улаанбаатар: Ном Хур Press.

Октябрьжаргал, Э., Мягмар, О., & Ичинхорлоо, Ш. (2018). Багшийн хандлагыг өөрийн төсөөллийн аргаар судалсан нь. Боловсролын чанар, үр дүн (хуудсд. 354-360). Улаанбаатар: EduPress.

Уртнасан, Г., Эрдэнэтуяа, С., & Оюун, Ц. (2018). Оюутны суралцахуйн хандлагыг үнэлэх боломжийн судалгаа. Боловсролын чанар, үр дүн (хуудсд. 410-419). Улаанбаатар: EduPress.

冯延勇, 苏缙, 胡兴旺, 李红. (2006). 大学生学习适应量表的编制. 心理学报,

762-769.

- 孙维胜. (2003). 论学生正确的学习态度及其培养. 当代教育科学, 13-15.
- 屈型杰. (2011). 小学生学习态度测验的初步编制. 湖南师范大学, 45.
- 巴特琳娜, K. T. (1981). 各年级学生的学习动机. 北京: 人民教育出版社.
- 张俊珍. (2006). 工科大学生学习态度现状调查及影响因素研究. 理工高教研究.
- 张俊珍. (2006. 5). 科技大学生学习态度现状调查及影响因素研究. 工高考研究, 67-71.
- 张宪尧. (1995.). 中学生学习态度调查研究. 台州师专学报, 1.
- 张波玲. (2014). 蒙汉大学生学习态度问卷初步编制及其应用. 蒙古师范大学, 21.
- 徐波玲. (2014). 蒙汉大学生学习态度问卷初步编制及其应用. 内蒙古师范大学, 34.
- 朱智贤. (1989). 心理学大辞典. 北京: 北京师范大学出版社.
- 李小兰. (2007). 转变高职大学生学习态度提高学习积极性的思考. 经济与社会发展.
- 李明振. (1994). 成就动机数学学习态度与学生数学学业成绩的关系. 贵州师范大学学报自然科学版, 12.
- 江立成. (2015). 大学生心理健康教育理论与实践新探索. 北京: 中国社会学出版社.
- 沈德立. (2002. 2). 中小学生的智力, 学习态度与其数学学业成就的相关性研究. 天津师范大学学报.
- 罗忠民, & 何高大. (2007). 大学生英语学习态度策略的调查报告. 教学研究.
- 联合国教科文组织. (1996). 学会生存-教育世界的今天和明天. 北京: 教育科学出版社.
- 邵瑞珍, & 皮连胜. (1997). 教育心理学. 上海: 上海教育出版社.
- 陶德清. (2001). 学习态度的理论与研究. 广州市: 广州人民出版社.


## **DEVELOPMENT AND VALIDATION OF AN INSTRUMENT TO ASSESS MONGOLIAN UNIVERSITY STUDENT' ATTITUDES TOWARDS LEARNING**

Tumentssetseg.B<sup>a</sup>, Namjildagva R<sup>b</sup>, Sarentana.O<sup>c</sup>

<sup>a</sup>Ph.D., Lecturer, Teachers School, MNUE;

<sup>b</sup>Assistant prof., Ph.D., School of Educational Studies, MNUE;

<sup>c</sup>Master, School of Educational Studies, MNUE

Corresponding author: o.sarantana@gmail.com 

### **Abstract**

Learning attitude considers three components: cognition based on the importance and goal of learning, emotion based on interest in learning, and behavior based on learning motivation (ABC model, Smith, 1940). "Learning Attitude Scale" was translated into Mongolian using Brislin's method. This scale measured the learning attitude of 498 students aged 18-28 (male-37.8%, female-62.2%) from 5 universities in Mongolia. The results of the research were analyzed using SPSS 25 and AR studio software, using component analysis and exploratory factor analysis. Students' attitude to learning is the impression and feeling (emotional component) arising during learning; opinions and beliefs about the subject (cognitive component); learning goals, motivation, and motivation (behavioral component) are important and closely related. Researchers can use this questionnaire to determine learning attitudes of Mongolian students.

### **Keywords**

Andragogy, learning attitudes, ABC model, questionnaire instrument

---